Хийн өвчний үед хэрэглэсэн эмийн хэрэглээг Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэнгийн эмнэлгийн жишээ дээр судалсан дүн

Б.Сийлэгмаа[1], Ч.Чимэдрагчаа[2], Б.Уганбаяр[2], Н.Оюунцэцэг[1]

[1]АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын сургууль, Уламжлалт эмчилгээний тэнхим
[2]Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэн
Цахим шуудан: siilegmaa10@gmail.com, Утас: 98000502

Түлхүүр үг:
Уламжлалт анагаах ухаан
Хий цусаар дээш хөөрөх
Хий долгисол
Нүүр нэг зүгт мурийх

Товч утга:
Үндэслэл: Монгол улсын “Эмийн бүртгэл”-д уламжлалт эм нь албан ёсоор бүртгэлтэй байдаг бөгөөд эдгээр эмийн эмнэлзүйн практикт хэрэглэж байгаа байдлыг хараахан судлаагүй байна. Иймд бид зонхилон тохиолдох өвчний нэг болох хийн өвчний үед хэрэглэж байгаа эмийн хэрэглээний байдлыг судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. **Зорилго:** Уламжлалт анагаах ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй УАУТХ-ийн эмнэлгийн хийн өвчний эмийн хэрэглээг судлах. **Арга, аргачлал:** Бид энэхүү судалгааг ретроспектив судалгааны аргаар баримтын загварыг ашиглан УАУТХ-ийн эмнэлэгт 2018-2020 оны хооронд хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчдийн өвчний түүхээс мэдээллийг цуглуулсан. Цуглуулсан мэдээллээ баримтын судалгааны арга, магадлан жагсаах аргуудаар судалж нэгтгэн, гарсан үр дүнгээ SPSS-25.0 программ ашиглан боловсруулалт хийсэн. **Үр дүн:** УАУТХ-ийн эмнэлгээр хэвтэн эмчлүүлсэн нийт үйлчлүүлэгчдээс 2018 онд 6358-аас 580 эмчлүүлэгч буюу 9.12%, 2019 онд 6610-аас 525 эмчлүүлэгч буюу 7.94%, 2020 онд 5938-аас 825 эмчлүүлэгч буюу 13.89% нь хийн өвчний оноштойгоор эмчлүүлсэн байна. Эдгээр хий өвчнийг дотор нь тавьсан оношоор ялгаж үзвэл 2018 онд 67.75%, 2019 онд 70.66%, 2020 онд 61.57% нь хий цусаар дээш хөөрөх оноштой эмчлүүлэгч байсан бол 2018 онд 27.93%, 2019 онд 23.61%, 2020 онд 30.18%нь хий долгисол, 2018 онд 3.96%, 2019 онд 6.66%, 2020 онд 7.15% нь тус тус нүүр нэг зүгт мурийх оноштойгоор эмчлүүлсэн байна. Тэдгээрт хийгдсэн эмийн эмчилгээнд дүн шинжилгээ хийж үзэхэд 2018-2020 оны хооронд Хий цусаар дээш хөөрөх оноштойгоор эмчлүүлсэн 1272 хүн байгаа бөгөөд Норов-7 танг 31.52%, Марчин-13 танг 30.18%, Агар-15 жорыг 26.17%, Сампилноров жорыг 21.77% бичсэн байна. Хий долгисол оноштойгоор эмчлүүлсэн 535 хүн байгаа бөгөөд Сорогзон-11 жорыг 33.83%, Сүгмэл-3 танг 32.71%, Агар-35 жорыг 26.91%, Норов-7 танг 26.54%, Нейровалин эмийг 21.68%, Сампилноров жорыг 20.56% тус тус бичигдсэн байна. Нүүр нэг зүгт мурийх оноштойгоор 117 хүн эмчлүүлсэн байгаа бөгөөд Норов-7 танг 50.42%, Сампилноров жорыг 42.73%, Шингүн-25 жорыг 38.46%, Агар-35 жорыг 32.47%, Гарьд-13 жорыг 30.76% тус тус бичсэн байна. **Дүгнэлт:** Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эмнэлэгт 2018-2020 оны хооронд хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 7.94-13.89% нь Хий цусаар дээш хөөрөх, Хий долгисол, Нүүр нэг зүгт мурийх гэсэн хийн өвчний оноштойгоор хэвтэн эмчлүүлсэн байгаа бөгөөд тэдгээр Марчин-13, Агар-15, Норов-7, Сампилноров жоруудыг хамгийн их хэрэглэсэн байна.

Үндэслэл: ДЭМБ-ын зүгээс дэлхийн улс орнуудад уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ хэрхэн хөгжиж байгаа, эрүүлийг хамгаалах тогтолцоонд (УАУ) ямар байр суурьтай байгаад тодорхой судалгаа, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид УАУ-ыг орчин үеийн анагаах ухаантай яаж уялдуулан хөгжүүлэх талаар гишүүн орнууддаа зөвлөмж өгсөөр байна.[1] Уламжлалт анагаах ухаан нь дэлхийн улс орнуудад орчин үеийн анагаах ухаантай мөр зэрэгцэн хэрэглэгддэг бөгөөд уламжлалт анагаах ухааныг аюулгүй бөгөөд үр дүн сайтай байдлаар ашиглах нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үнэтэй хувь нэмэр оруулдаг.[2]

Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүд батлагдан гарсан байна. Тухайлбал, Монгол улс 1999 онд

“Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого“-ыг Улсын Их Хурлаар батлсан нь нийтлэг үндэслэл, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх төрийн бодлогын үндсэн чиглэл гэсэн 2 бүлэг, 19 заалттай бөгөөд манай орныг ДЭМБ-ын гишүүн 192 орноос УАУ-ны талаар төрийн бодлоготой 25 орны нэг бөгөөд УАУ-ны нэгдмэл тогтолцоотой улс орон болгосон нэн чухал ач холбогдолтой түүхэн баримт бичиг юм.[3,4] Уламжлалт анагаах ухааны төрөөс баримтлах бодлогод 2015 он хүртэл баримтлах үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлсон ба тухайн цаг хугацаанд хүрсэн түвшин, бий болсон материаллаг бааз, хүний нөөцийн хангамж зэргийг үнэлэн цэгнэхийн хамт цаашид улсын хэмжээнд уламжлалт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, чанартай найдвартай үзүүлдэг болгох үүднээс төрөөс баримтлах чиглэлүүд тодорхойлогдсон.[5] Монголын уламжлалт анагаах ухааны хууль эрх зүйн орчин, тусламж үйлчилгээний чиглэл, хандлагыг “Ази-Номхон Далайн бүсийн орнуудын Уламжлалт Анагаах Ухааны Стратеги” (2011-2020)-тэй уялдуулсан үнэлгээ 2012 онд хийгдсэн боловч эмнэлзүйн тусламж үйлчилгээг нарийсган судалсан судалгаа ховор байна.[6] Судлаач З.Гүндалай (2020) нар уламжлалт эмчилгээний өртөг зардлыг “Хий цусаар дээш хөөрөх” өвчний жишээн дээр эмчилгээний хувьсах зардлыг тооцож судалсан байдаг.[7]

Манай улсад УАУ-ы тусламж үйлчилгээ нь лавлагаа шатлалын нийслэл, аймгийн болон дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгүүд гэсэн шатлалтай хэрэгжиж байна. Дээрх эмнэлгүүдэд уламжлалт анагаах ухааны урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээ, эмнэлзүйн заавар, стандартууд бүрэн боловсрогдон гараагүй, уламжлалт эмчилгээний тусламж эрхэлдэг эрүүл мэндийн байгууллагуудын мэргэжлийн боловсон хүчний нөөц зэрэг нь хараахан судлагдаж, тодорхойлогдоогүй асуудлууд байгааг судлаачид тэмдэглэсэн байна. Энэхүү нөхцөл байдал нь уламжлалт анагаах ухааны цаашдын хөгжлийг тодорхойлох, эмнэлзүйн тусламж үйлчилгээний менежментийг боловсронгуй болгоход тулгамдсан асуудал болж байна. Монгол улсын “Эмийн бүртгэл”-д уламжлалт эм нь албан ёсоор бүртгэлтэй байдаг бөгөөд эдгээр эмийн эмнэлзүйн практикт хэрэглэж байгаа байдлыг хараахан судлаагүй байна. Иймд бид зонхилон тохиолдох өвчний нэг болох хийн өвчний үед хэрэглэж байгаа эмийн хэрэглээний байдлыг судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Зорилго: Уламжлалт анагаах ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй УАУТХ-ийн эмнэлгийн хийн өвчний эмийн хэрэглээг судлан тодорхойлох.

Зорилт:

1. Хийн өвчний оноштойгоор эмчлүүлсэн үйлчлүүлэгчдийн эзлэх хувийг тогтоох
2. Хийн өвчний үед хэрэглэгдэж байгаа уламжлалт эмийн нэр төрөл, хэрэглээний түвшинг тодорхойлох

Арга, аргачлал: Бид ретроспектив судалгааны аргаар баримтын загвараар Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэнгийн Төв эмнэлгээр 2018-2020 оны хооронд үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн өвчний түүхийг ашиглан хийн өвчний оношоор уламжлалт анагаах ухааны эмнэлгээс тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн эмийн хэрэглээг судлах баримтын судалгаа хийсэн.

Судалгааны ажлын арга зүйг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж судалгаа хийх ёс зүйн зөвшөөрөл (2022/3-01) авсан.


Судалгааны ажлын үр дүнг биостатистикийн үндсэн аргуудаар арифметик дундаж, итгэмжлэх хязгаар (CI-95%) болон дундаж тооны үнэн магадлалыг Стьюдентийн t шалгууураар шалган, боловсруулалтыг SPSS 25.0 программ ашиглан хийсэн.

Үр дүн: Бид тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчдээс хийн өвчний оноштойгоор эмчлүүлсэн эмчлүүлэгчдийн нийт тоог тодорхойлов. УАУТХ-ийн эмнэлгээр хэвтэн эмчлүүлсэн нийт үйлчлүүлэгчдээс 2018 онд 9.12%, 2019 онд 7.94%, 2020 онд 13.89% нь хийн өвчний оноштойгоор эмчлүүлсэн нь тодорхойлогдлоо. Үүнээс харахад 2020 онд хийн өвчний оноштой эмчлүүлэгч хамгийн их байсан болох нь тодорхойлогдлоо. (Зураг 1)



Зураг 1. Хийн өвчний оноштойгоор УАУТХ-ийн эмнэлгээр эмчлүүлэгсэд

Хийн өвчнийг ангиллын дагуух оношоор ялгаж үзвэл 2018 онд 67.75%, 2019 онд 70.66%, 2020 онд 61.57% нь хий цусаар дээш хөөрөх оноштой эмчлүүлэгч байсан бол 2018 онд 27.93%, 2019 онд 23.61%, 2020 онд 30.18% нь хий долгисол, 2018 онд 3.96%, 2019 онд 6.66%, 2020 онд 7.15% нь тус тус нүүр нэг зүгт мурийх оноштойгоор эмчлүүлсэн байна. Дээрх үр дүнгээс харахад 2019 онд хий цусаар дээш хөөрөх өвчний оноштой эмчлүүлэгч, 2020 онд хий долгисол болон нүүр нэг зүгт мурийх оноштой эмчлүүлэгчид дийлэнх хувийг эзэлж байсан байна. (Зураг 2)



Зураг 2. УАУТХ-ийн эмнэлгээр эмчлүүлсэн хийн өвчний судалсан дүн

Мөн бид дээрх хийн өвчний оноштойгоор эмчлүүлсэн эмчлүүлэгчдэд хэрэглэсэн эмүүдийг судлан тогтоосон.

2018-2020 оны хооронд Хий цусаар дээш

хөөрөх оноштойгоор эмчлүүлсэн 1272 хүн байгаа бөгөөд Норов-7 танг 31.52%, Марчин-13 танг 30.18%, Агар-15 жорыг 26.17%, Сампилноров жорыг 21.77% хэрэглэсэн байна. Хий долгисол оноштойгоор эмчлүүлсэн 535 хүн байгаа бөгөөд Сорогзон-11 жорыг 33.83%, Сүгмэл-3 танг 32.71%, Агар-35 жорыг 26.91%, Норов-7 танг 26.54%, Нейровалин эмийг 21.68%, Сампилноров жорыг 20.56% тус тус хэрэглэжээ. Нүүр нэг зүгт мурийх оноштойгоор 117 хүн эмчлүүлсэн бөгөөд Норов-7 танг 50.42%, Сампилноров жорыг 42.73%, Шингүн-25 жорыг 38.46%, Агар-35 жорыг 32.47%, Гарьд-13 жорыг 30.76% тус тус хэрэглэсэн нь тодорхойлогдлоо. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Хийн өвчнийг анагаахад хэрэглэсэн эмүүд

Эмийн нэр	Хий цусаар дээш хөөрөх (1272)	Хий долгисол (535)	Нүүр нэг зүгт мурийх (117)
Норов-7	401	142	59
Марчин-13	384	12	10
Агар-35	324	144	38
Агар-15	333	34	10
Сампилноров	277	110	50
Сорогзон-11	127	181	7
Сүгмэл-3	117	175	22
Нейровалин	274	116	15
Шингүн-25	95	82	45
Гарьд-13	76	36	31

Хэлцэмж: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа-2050”-ийн 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.23-т “Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гарах гарцыг дэмжин “брэнд” болгоно” хэмээн төлөвлөсөн байна.[8] Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн А/55 тоот тушаалаар Уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, код шинэчлэн батлагдсан.[9] Энэхүү тушаалд хий өвчнийг дотор нь 36 дэд бүлэг болгон ангилсан байдаг бөгөөд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн төв эмнэлэгт дээрх ангиллын өвчнүүдээс Хий цусаар дээш хөөрөх, Хий долгисол болон Нүүр нэг зүгт мурийх гэсэн онош бүхий эмчлүүлэгчид илүү олон байсан байна.[10]

Судлаач Б.Энхжаргал нарын судалгаагаар Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эмнэлэгт 2011-2015 оны хооронд эмчлүүлсэн үйлчлүүлэгчдийн зонхилон тохиолдох өвчний ангилалыг судалсан байгаа бөгөөд үр дүнгээс харахад Хий цусаар дээш хөөрөх оноштой эмчлүүлэгч 2011 онд 8.03%, 2012 онд 5.91%, 2013 онд 9.0%, 2014 онд 7.19%, 2015 онд 5.38%-ийг эзэлж байсан байна.[11] Эдгээр эмчлүүлэгчдийн эмчилгээнд бичигдсэн эмийг Уламжлалт анагаах ухааны зонхилон тохиолдох өвчний оношлогоо, эмчилгээний эмнэлзүйн удирдамжид бичигдсэн эмүүдтэй харьцуулж үзэхэд Хий цусаар дээш хөөрөх өвчнийг анагаах үндсэн эмүүдээс Марчин-13, Агар-15, Тагтаггүнсэл, увдисын Гүргэм-13, Тунгалаг-5 жор, хавсран уух эмүүдээс Задь-5, Арүр-10, Сэма-3, Сампилноров жорыг хэрэглэхээр заасан байсан бол Хий долгисол өвчнийг анагаах үндсэн эмүүдээс Сорогзон-11, Сампилноров, Агар-35, Нейровалин эм, хавсран хэрэглэх эмүүдээс Сүгмэл-3, Жамц-4, Шижид-6, Сэрдэг-5 жоруудыг хэрэглэхээр бичсэн байгаагаас үзэхэд уг эмнэлгийн эмч нар дээрх оношлогоо эмчилгээний удирдамжийг мөрдөн ажиллахаас гадна эдгээр эмүүд нь улсын бүртгэлд бүргэгдсэн байна.[12]

Мөн Susannah Deane нарын хийсэн судалгаагаар хийн өвчнийг эмчлэхэд Агар, Лиш, Сармис зэрэг түүхий эдүүд орсон уламжлалт эмүүдийг түлхүү хэрэглэдэг болохыг тогтоосонтой дүйж байна.[13]

Дүгнэлт:

1. Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эмнэлэгт 2018-2020 онд хэвтэн эмчлүүлэгсдийн 10.31%-ийг хийн өвчний оноштой эмчлүүлэгч, тэдгээрийн 66%-ийг хий цусаар дээш хөөрөх өвчин, 27%-ийг хий долгисол, 7%-ийг нүүр нэг зүгт муруйх өвчин эзэлж буйг тогтоолоо.
2. Хий цусаар дээш хөөрөх, хий долгисол, нүүр нэг зүгт муруйх зэрэг язгуурын хийн өвчнүүдийн үед Агар-35, Сорогзон-11, Марчин-13, Сампилноров зэрэг 10 төрлийн уламжлалт эмийг голчлон хэрэглэсэн нь 100% улсын эмийн бүртгэлд бүртгэлтэй байна.

Ном зүй:

1. *Стратегия ВОЗ в области народной медицины 2014-2023гг:2002:25-26*
2. *Номхон далайн баруун эргийн уламжлалт анагаах ухааны бүсийн стратеги (2011-2020)*
3. *Монголын уламжлалт анагаах ухааны талаар төрөөс баримтлах бодлого.pdf. Published online 1999.*
4. *Төрөөс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлого.pdf. Published online 2017.*
5. *С.Ламбаа. Монголын уламжлалт анагаах ухааны түүхэн хөгжил, өнөөгийн байдал, хэтийн төлөв. Монголын анагаах ухаан. 2009;3:149.*
6. *“Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого 1999-2015“, 1999 он.*
7. *З.Гүндалай. Уламжлалт Анагаах Ухаан дахь “Хий цусаар дээш хөөрөх” (ТМА 02.16) өвчний эмчилгээний хувьсах зардлыг тооцох сэдэвт Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл УБ 2020 он*
8. *Монгол улсын их хурлын тогтоол. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай. 2020.05.13. Дугаар 52. Х*
9. *ЭМС-ын тушаал. Уламжлалт анагаах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, код шинэчлэн батлах тухай А/55 тоот тушаал. 2022.01.28.*
10. *Уламжлалт анагаах ухааны зонхилон тохиолдох өвчний оношлогоо, эмчилгээний эмнэлзүйн удирдамж. Улаанбаатар хот. Хөх монгол принтинг. 2013 он. х.27-69.*
11. *Энхжаргал Б., Батцэцэг Д., Тогоохүү Ц. УАУ-ны зонхилон тохиолдох өвчний ангилал, кодлол. Монголын уламжлалт анагаах ухаан. 2016. х.32-34.*
12. *http://www.druginfo.mohs.mn/#ViewID=UDB_DISProductQuantity_ListView&ObjectClassName=UIS.UDB_DISProductQuantity*
13. *Susannah Deane. rLung, Mind, and Mental Health: The Notion of “Wind” in Tibetan Conceptions of Mind and Mental Illness. Journal of Religion and Health (2019) 58:708–724.*

Research of recipe used to therapy wind disease based on case studies conducted by the Institute of Traditional Medicine and technology

Siilegmaa B[1], Uuganbayr B[2], Chimedragchaa Ch[2], Oyuntsetseg N[1]

[1]MNUMS, School of International Mongolian Medicine
[2]Institute of Traditional Medicine and Technology
E-mail: siilegmaa10@gmail.com, Tel: +976-98000502

Background: Traditional medicines are officially registered in the "Register of drug" of Mongolia, and the usage of recipe in clinical practice has not yet been studied.
Aim: To study and determine the use of drugs for wind diseases in the ITMT of hospital, working in the field of traditional recipe.
Materials and Methods: The study was conducted using a case study method using a retrospective study method, and data were collected from the case histories of clients who were hospitalized at the ITMT of hospital in the period from 2018 to 2020. The information collected was analyzed and summarized by fact-finding methods and probability list methods and the results were processed using SPSS-25.0 software.
Results: In 2018, 580 of 6358 patients or 9.12%, 525 of 6610 patients or 7.94% in 2019 and 825 of 5938 patients or 13.89% in 2020 were diagnosed with wind disease. If we distinguish these wind diseases by diagnosis, then in 2018 - 67.75%, in 2019 - 70.66%, in 2020- 61.57% pathways where wind and blood run, and in 2018 - 27.93%, in 2019 - 23.61% and in 2020, 30.18% were diagnosed with agitation caused by wind, in 2018-3.96%, in 2019 - 6.66%, in 2020 - 7.15% were treated with a diagnosis of facial palsy. Analyzing the medical treatment carried out in them, from 2018 to 2020, 1272 people diagnosed with pathways where wind and blood run were treated, of which 31.52% prescribed Norov-7, 30.18% Marchin-13, 26.17% Agar-15 and 21.77% Sampilnorov. 535 people diagnosed with agitation caused by wind were treated, of which 33.83% were prescribed Sorogzon-11, 32.71% Sugmel-3, 26.91% Agar-35, 26.54% Norov-7, 21.68% Neurovalin and 20.56% of Sampilnorov. 117 people with a diagnosis of facial palsy were treated, 50.42% were prescribed Norov-7, 42.73%- Sampilnorov, 38.46% - Shingun-25, 32.47% - Agar-35, 30.76% - Gardi-13.
Conclusion: In the period from 2018 to 2020, 10.31% of clients admitted to the ITMT hospital were hospitalized with a diagnosis of wind diseases a time. These were Marchin-13 and Agar-15, the most commonly used recipes were Norov-7 and Sampilnorov.

Keywords: Traditional medicine, Pathways where wind and blood run, Agitation caused by wind, Facial palsy